

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 402.

Арвайхээр

Мэргэжлийн яаралтай тусламж үзүүлэх  
багуудыг томилох тухай

Монгол Улсын Шадар Сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны “Журам батлах тухай” 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжиг илэрсэн, өвчлөл гарсан тохиолдолд нарийн мэргэжлийн яаралтай тусламж үзүүлэх багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Нарийн мэргэжлийн яаралтай тусламж үзүүлэх багийн бүрэлдэхүүнд орсон эмч, мэргэжилтнүүдийн хийж гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг гаргах, зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, оношлох, эмчлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахих тусгай сургалт явуулж, дадлага эзэмшүүлэн бэлэн байдлыг хангуулах, ээлжийн амралтыг өвчлөл гарч болзошгүй улиралд зохицуулах арга хэмжээ авахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Э. Хүдэрчулуун), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3. Хавсралтаар батлагдсан эмч, мэргэжилтний томилгоог жил бүрийн 1 дугаар улиралд багтаан тодотгож байхыг Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д даалгасугай.


4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААНҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны  
12 сарын 22 ны өдрийн 102 р тушаалын  
хавсралт



МЭРГЭЖЛИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ  
БАГУУДЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Мэргэжил	1-р баг	Ажлын газар	2-р баг	Ажлын газар
1	Халдвар судлагч их эмч /ажлын хэсгийн ахлагч/	Б. Сүхбаатар	ЗӨСТ	Э.Лхагвадулам	ЭМГ
2	Халдвар судлагч их эмч	Г.Надмидсүрэн	БОЭТ	Д.Сайнжаргал	БОЭТ
3	Халдвартын их эмч	Ж.Дэмиддолгор	БОЭТ	Ч.Эрдэнэтуяа	БОЭТ
4	Нян судлагч их эмч	С.Сосорбурам	ЗӨСТ	С.Хоролмаа	ЗӨСТ
5	Дотрын их эмч	Б.Баяртогтох	БОЭТ	Г.Сувданцэцэг	БОЭТ
6	Хүүхдийн их эмч	Б.Дэлгэрмаа	БОЭТ	М.Болормаа	БОЭТ
7	Биологич	Л.Мэнд-Амар	ЗӨСТ	Б.Ганбат	ЗӨСТ
8	Эмгэг анатомийн лаборант	Д.Хоролсүрэн	БОЭТ	Э.Туул	БОЭТ
9	Нян судлалын лаборант	Б.Саранзаяа	ЗӨСТ	Н.Гэрэлчимэг	ЗӨСТ
10	Клиникийн лаборант	Б.Дүгэр	БОЭТ	Т.Тунгалагцэцэг	БОЭТ
11	Сувилагч	Г.Отгонсүрэн	БОЭТ	Н.Чимэддулам	БОЭТ
12	Сувилагч	Ц.Үржинчимэг	БОЭТ	Р.Оюунтүлхүүр	БОЭТ
13	Ариутгагч	А.Өлзиймаа	ЗӨСТ	Н.Лусмаа	БОЭТ
14	Үйлчлэгч	Х.Энхсүрэн	БОЭТ	Н.Банзрагч	БОЭТ
15	Үйлчлэгч	Т. Азжаргал	БОЭТ	Ц.Оюунбаяр	БОЭТ
16	Жолооч	Б.Гончигсүм	ЗӨСТ	О.Базаррагчаа	ЭМГ
17	Жолооч	Т.Дашдорж	БОЭТ	О.Гантөр	БОЭТ